

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД, САНГИЙН САЙД, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН
ХАМГААЛЛЫН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2020 оны 4 дүгээр сарын 10-ны өдөр

Дугаар А/62/78/А/89

Улаанбаатар хот

**АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН АЖИЛТАНД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ОЛГОХ ШАЛГУУР
ҮЗҮҮЛЭЛТИЙГ ТОГТООХ ТУХАЙ**

Төрийн албаны тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсэг, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 5 дугаар хавсралтаар баталсан "Төрийн үйлчилгээний албан хаагчид мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох нийтлэг журам"-ын 7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Архив, албан хэрэг хөтлөлтийн ажилтанд мэргэшлийн зэрэг олгоход тавигдах шалгуур үзүүлэлт"-ийг хавсралт ёсоор баталсугай.
2. Тушаалыг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Билгүүн/, Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга /С.Наранцогт/, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн дарга /Г.Өнөрбаяр/ нарт үүрэг болгосугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд/хуучнаар/-ын хамтран баталсан 2005 оны 15/41/25 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ
САНГИЙН САЙД Ч.ХҮРЭЛБААТАР
ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД С.ЧИНЗОРИГ